



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 1988

Улаанбаатар хот

Б.Ариунтуяад ёс зүйн хариуцлага
хүлээлгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, 12 дугаар зүйлийн 12.1.5, 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батмөнхийн Ариунтуяа нь төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага, хэм хэмжээг зөрчсөн нь Ёс зүйн дэд хорооны 10 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр дүгнэлтээр тогтоогдсон тул түүнд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс “Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах” ёс зүйн хариуцлага ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, ёс зүйн нийтлэг шаардлага, хэм хэмжээг мөрдөн, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ариунтуяад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (С.Оюун-Эрдэнэ)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д. ДЭЛГЭРСАЙХАН



112402198